



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Консерватори,  
Хөгжмийн ухаан, дуулаачийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Дуулах урлаг  
Индекс: D021503

Шинжээчийн баг:

Ахлагч: А. Энхбат  
Гишүүд: Л. Мөнхтуяа  
Н. Дашбямба

Он сар өдөр: 2020.06.04

## Агуулга

<b>Товчилсон үгийн тайлбар .....</b>	<b>2</b>
<b>I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт .....</b>	<b>3</b>
<b>II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга .....</b>	<b>4</b>
<b>III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт .....</b>	<b>6</b>
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .....	5
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа .....	7
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .....	8
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	10
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа .....	12
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа .....	16
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт .....	18
<b>IV. Уулзалтад оролцогчдын нэрс .....</b>	<b>22</b>
I. Багш нарын нэрс .....	22
II. Оюутнуудын нэрс .....	23
III. Ажил олгогчдын нэрс.....	24
IV. Төгсөгчдийн нэрс .....	25
V. Шинжээчийн багийн ажиллах хуваарь .....	26
<b>V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал .....</b>	<b>27</b>
<b>ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр .....</b>	<b>28</b>
<b>ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр .....</b>	<b>29</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- БМИУЗ Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
- БСШУСЯ Боловсрол, соёл, шинжлэх ухааны спортын яам
- ДБСБ Дээд боловсролын сургалтын байгууллага
- МУК Монгол Улсын Консерватори
- ХБК Хөгжим бүжгийн коллеж
- ТАЗ Төрийн албаны зөвлөл
- СнЗ Сайд нарын зөвлөл
- СХМС Сонгодог хөгжмийн мэргэжлийн сургууль
- ҮХМС Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургууль
- БЦМС Бүжиг, Циркийн мэргэжлийн сургууль
- ХУДС Хөгжмийн ухаан, Дуулаачийн сургууль
- СБЗГ Сургалтын бодлого зохицуулалтын газар
- СНҮА Санхүү, нийтлэг үйлчилгээний алба
- ДХШҮА Дотоод хяналт шинжилгээ үнэлгээний алба
- УБМА Уран бүтээл, маркетингийн алба
- ЭШИА Эрдэм шинжилгээ инновацийн алба
- ГХТХА Гадаад харилцаа, төсөл хөтөлбөрийн алба
- БНМАУ Бүгд найрамдах Монгол ард улс
- ХБДС Хөгжим бүжгийн дунд сургууль
- СУИС Соёл урлагийн их сургууль
- ЕБС Ерөнхий боловсролын сургууль
- МТХТ Мэргэжлийн төгөлдөр хуурын тэнхим
- ДТ Дуулаачийн тэнхим
- ЗХУ Зөвлөлт холбоот улс
- ОХУ Оросын холбооны улс
- БНХАУ Бүгд найрамдах Хятад ард улс
- АНУ Америкийн нэгдсэн улс
- ХБНГУ Холбооны бүгд найрамдах Герман улс
- БНСУ Бүгд найрамдах Солонгос улс
- ӨМӨЗО Өвөр Монголын өөртөө засах орон
- ДБЭТ Дуурь бүжгийн эрдмийн театр
- ҮУИТ Үндэсний урлагийн их театр
- ЭСЯ Элчин сайдын яам
- ХДТ Хөгжимт драмын театр
- АЖ Ардын жүжигчин

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Монгол Улсын Консерваторийн Хөгжмийн ухаан дуулаачийн сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Дуулах урлаг	
<b>Индекс</b>	D021503	
<b>Шинжээчид</b>	А.Энхбат – Шинжлэх Ухаан Технологийн их сургуулийн Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн захирал, шинжээчийн багийн ахлагч Л.Мөнхтуяа – Монгол Улсын Боловсролын их сургуулийн Зайны сургалтын албаны дарга, шинжээчийн багийн гишүүн Н.Дашбямба- Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрын ерөнхий хормейстер, шинжээчийн багийн гишүүн	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Б.Мядагмаа – БМИҮЗ-ийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2020.05.25-26	Ажилласан хуваарийг хавсаргав.
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06-р сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ын дагуу ажиллав.	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

---

Монгол Улсын Консерваторийн түүхэнд 1950 оны 9 сарын 1-ээс эхлэн Найрал дууны үндсэн анги хичээллэхээр сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхэлжээ. 1960 оны эхээр анхны багшаар Улсын алдарт гавъяат дуучин Ж.Дорждагва, МУАЖ, Хөдөлмөрийн баатар Б.Зангад, Ж.Дамиран 1962-1966 он, МУГЖ профессор Ж.Цэцгээ 1966-1967, МУУГЗ Ч.Жамсранжав хормейстр багшаар ажиллаж байсан. 1993 онд Дуучдыг бэлтгэх анги дахин нээж, анх 8-р анги төгссөн хүүхдүүдийг элсүүлэн дунд боловсролтойгоор 2 удаа төгсөлт хийсэн нь дуулах ур зүйн суурь боловсрол эзэмшсэн сайн дуучид төрөн гарсан болно. 2000 оноос эхлэн М.Булганы удирдлагаар бакалаврын түвшингийн төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж анхны бакалаврын түвшингийн сургалтыг дуулаачийн элсэгчдээс эхэлсэн түүхтэй. 2003 оноос бакалаврын боловсролтой мэргэжлийн Дуурийн болон Уртын дуучид бэлтгэж, 2007-2019 он хүртэл 13 төгсөлт дүүргэсэн. Тогтмол оролцдог олон улсын уралдаан тэмцээн

- М.Глинкийн нэрэмжит дуурийн дуу дуулаачдын олон улсын уралдаан
- Австри улсын Линз хотод зохиогдсон “Competitione dell” opera хэмээх дэлхийн А зэрэглэлийн уралдаан
- П.И.Чайковский нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын уралдаан
- ОХУ-н ардын жүжигчин Галина Вишневскаягийн нэрэмжит дуурийн дуулаачдын олон улсын уралдаан
- ОХУ-н Ардын жүжигчин Лхасаран Линховойны нэрэмжит дуурийн залуу дуучдын олон улсын уралдаан
- Муслим Магомаевын нэрэмжит олон улсын дуурийн дуулаачдын уралдаан
- Н.А.Римский Карсоковын Дуурийн дуулаачдын олон улсын уралдаан
- К.Базарсадаева нэрэмжит олон улсын мэргэжлийн дуулаачдын уралдаан зэрэг олон улсын уралдааны шагналт олон арван төгсөгчдийг төрүүлсэн хөтөлбөр.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:** Соёл урлагийн их сургууль, Сити их сургуулийн ижил хөтөлбөрөөс гадна ОХУ-ын Гнесиний нэрэмжит хөгжмийн академи, ОХУ-ын М.И.Глинкийн нэрэмжит хөгжмийн сургууль, Итали улсын Венеци хотын Benedetto Marcello Хөгжмийн дээд сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийсэн байна. Хөтөлбөрийн сургалтанд оролцогч талууд идэвхтэй хамтардаг, уралдаан тэмцээн тогтмол явуулдаг байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг бүрэн баримжаалсан. Монгол үндэсний дуулах урлагийн дэг сургуулийг бий болгож, хөгжүүлж, өвлүүлж, уламжилж чадаж байна.
- Хөтөлбөрийг боловсруулахдаа гадаадын болон дотоодын ижил хөтөлбөртэй харьцуулалт хийсэн.
- Тухайн хөтөлбөрөөр төгсөгчийн 90 гаруй хувь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн гэж үзэж болох том онцлог давуу тал юм.

##### Анхаарах асуудал:

- Ажил олгогч, төгсөгч, оюутнуудыг хөтөлбөрийн хөгжүүлэлтэд татан оролцуулдаг байх.
- Хөтөлбөрийн төгсөгч оюутнууд, ажил олгогч нар болон бусад оролцогч талуудыг хөтөлбөрийн агуулгын шинэчлэлт, өөрчлөлтөнд оролцуулах асуудал тогтмол хийдэггүй байна.

##### Зөвлөмж:

- Ажил олгогч, төгсөгч, оюутнуудыг хөтөлбөрийн хөгжил, шинэчлэлд идэвхтэй оролцогч, санаачлагч болоход нь дэмжиж санаа бодлыг нь сонсдог байх.
- Сонирхогч талуудын хэрэгцээнд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарч түүнд чиглэсэн судалгаандаа дүн шинжилгээ хийдэг байх

##### 1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:** Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилттой бүрэн нийцсэн. Мэргэжлийн салбар болон оролцогч талуудаас авсан судалгаануудтай. Төгсөгчдийн гавьяа шагнал, уралдаан тэмцээний шагналууд, тэтгэлэг, батламж, дипломууд байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой Монгол дуулах урлагийн дэг сургуулийг бий болгон дэлхийн дуулах урлагийн сонгодог дэгтэй хөл нийлсэн.
- Монголын төдийгүй дэлхийн тайзнаа гарч дуулж байгаа олон уран бүтээлч, дуучдыг төрүүлжээ.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр суралцагсад төгсөгчдийн эзэмшсэн, мэдлэг, ур чадвар нь мэргэжлийн түвшинд сайнаар үнэлэгдэж байгаа ч багаар ажиллах харилцааны соёл болон бусад харилцаа хандлагын чиглэлийг анхаарах шаардлага байгааг ажил олгогчдын зүгээс санал болгож байв.

#### **Зөвлөмж:**

- Оролцогч талуудын ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн шаардлагад нийцсэн мэргэжилтнийг бэлтгэхэд хөтөлбөрийн агуулгуудыг чиглүүлэх. Ялангуяа хандлага, төлөвшлийг зөв баримжаатай болгоход анхаарч, харилцааны соёл, ёс зүйн хичээлүүдийг сургалтын хөтөлбөрт нэмж заах.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:** Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр бүрэн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш төвтэй, ганцаарчилсан сургалт голлох тул багш, оюутны харилцан ойлголцол үнэхээр сайн байна. Багш нар ажилдаа чин сэтгэлтэй хандаж байна.
- Ганцаарчилсан сургалтын дэг бүрдэж, хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадварт чиглэсэн арга зүйг амжилттай хэрэгжүүлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн төлөвлөлт, баримт бичгийг тасралтгүй боловсруулан сайжруулах нөхцөл байдал гүйцэд төлөвшөөгүй байна.
- Хөтөлбөр, мэргэжлийн онцлогоос хамаарч зайны сургалтыг үр дүнтэй явуулах боломж тааруу байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн тасралтгүй сайжруулалтанд анхаарч хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороог яаралтай төлөвшүүлэх
- Хөтөлбөрийн сургалтын арга зүйг үр дүнтэй нь холбож урамшуулал, дэмжлэг үзүүлдэг байх

- Хөтөлбөрийн үнэлгээнд сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх

### 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

#### Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- Бакалаврын сургалтын төлөвлөгөө (D021503, 133 багц, 2018.11.23).
- Хөтөлбөрийн дэд хороо хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, хуралддаг (Протокол)
- Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын эзэмшвэл зохих цогц чадамжийн матрицтай (PLO, CLO)
- Дадлага ажлын удирдамжтай (2019.11.11.01 A/131, 50 дугаар хавсралт) байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага

- Хичээл хоорондын уялдаа холбоог тогтоох, шинэчлэл хийх хэлэлцүүлэг явагдаж хэвшсэн.

#### Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлэгт ажил олгогч, бусад оролцогч талуудын төлөөллийн саналыг авах

#### Зөвлөмж:

- Оюутнуудын дадлага удирдсан байгууллагаас санал авах, үйл ажиллагаандаа тусгах.
- Дадлага хийсэн оюутнуудын үнэлгээнд анализ хийж, сан үүсгэх. Мөн хөтөлбөрийн хөгжилд тусгах.

#### 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд программын шинэчлэл хийж байна. Лекц, семинар болон ганцаарчилсан сургалтын үед ашиглах арга зүйн хүрээг тодорхойлсон. Мөн багш нар суралцагчдын онцлогийг харгалзсан өөрийн сайн арга зүйтэй.
- МУК нь Их сургуулийн үүлэн системийн үйлчилгээний гэрээ байгуулсан (2019.08.25, АҮ-020)
- Цахим сургалт зохион байгуулах журам (2020.04.20, А/39) байна.

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан



### **Онцлог зүйл/Туршлага:**

- Системд байршсан цахим хэрэглэгдэхүүний сантай болсон (558 файл)

### **Анхаарах асуудал:**

- Судалгааны хэрэглэгдэгдэхүүний санг баяжуулах (Зохиогчийн эрхийн зөрчилгүйгээр цахимжуулах)

### **Зөвлөмж:**

- Багш, оюутнуудад удирдлага мэдээллийн систем ашиглах арга зүйн зөвлөмж, удирдамж боловсруулж, системд байршуулах.
- Багш нар өөрийн арга зүй бүхий аудио, видео болон бусад хэлбэрийн хэрэглэгдэхүүнийг системд байршуулах, баяжуулах.
- Системд хөтөлбөрийг нээлттэй болгох.

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- МУК-ын сургалтын журам (2018.11.23)

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш голлох ганцаарчилсан сургалт ихтэй учир үнэлгээ илүү бодиттой.

### **Анхаарах асуудал:**

- Тус хөтөлбөрөөр харилцан адилгүй төвшний суралцагч элсдэг.
- Блүмийн таксономид суурилсан сорил, даалгавар боловсруулдаг гэж дурдсан ч боловсруулалт харилцан адилгүй байна.

### **Зөвлөмж:**

- Гарааны үнэлгээний журам боловсруулж, хэрэгжүүлэх. (хүрсэн байх үр дүн буюу цогц чадамжийг л тодорхойлсон)
- Онлайнээр сургалт зохион байгуулж буй үед гүйцэтгэлд суурилсан үнэлгээ хийх арга зүй боловсруулах.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

## **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын орчин, анги танхим, лаборатори, багшийн сургалт явуулах өрөө, сургалтын өрөө хангалттай стандартад нийцсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Цахим хэрэглэгдэхүүний сан ашиглах лабораторитой.

### **Анхаарах асуудал:**

- Оюутнууд сургуулийн цайны газрын хоолны амт чанар муу, үнэтэй зэрэгт оюутнууд сэтгэл ханамжгүй байдаг.

### **Зөвлөмж:**

- Оюутны бэлтгэл, дадлага хийх өрөөг нэмэгдүүлэх.
- Оюутны цайны газарт онцгой анхаарал хандуулах.

## **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Дуулах урлаг хөтөлбөрт шаардлагатай сургалт, судалгааны материаллаг нөөцтэй.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Жил бүр цахим хэрэглэгдэхүүний сангийн баяжилт хийгдэж байна

### **Анхаарах асуудал:**

- Оюутнууд нот бичих зэрэг мэргэжлийн программ хангамжийг нэмэгдүүлэх.
- Зайны сургалтын үед дадлага хийх боломж харилцан адилгүй байсныг анхаарах

### **Зөвлөмж:**

- Анги, танхимыг жигд тохижуулах
- Багш оюутныг мэргэжлийн программ хангамж бүхий цахим хэрэглэгдэхүүнээр хангах

## **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн ном сурах бичигтэй, цахим номын сантай, дижитал сургалтын эх үүсвэртэй.
- Мэргэжлийн хичээл явуулах тасалгаа бүр төгөлдөр хуур, гарын авлага нот, CD, DVD хангагдсан.
- АЖ Д.Жаргалсайхан, Алдарт дууч МУГЖ Ж. Дорждагвын нэрэмжит өрөөг тохижуулан, тухайн хүний алдрын болон ном сургалтын хэрэгслийг бүрдүүлсэн.
- Концерт, сургалтын хоёр их танхимтай бөгөөд акустик дуугаралтанд сөрөг нөлөөлөлгүйгээр гэрэл, зөөлөн эдлэл, тайзны жижиг хэрэгсэл зэргийг сайжруулан шинэчлэсэн байна.
- Орчин үеийн дуу дүрсний төхөөрөмж суурилуулан тоглолт, концерт аливаа үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд явуулах нөхцлөөр хангагдсан.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн онцлог бүхий CD, пянзны баялаг материалтай.

### Анхаарах асуудал:

- Номын фондын баяжилтыг тогтмол хийх.
- Ховор эх материалуудыг цахимжуулах

### Зөвлөмж:

- Англи хэлээр бичигдсэн ном, сурах бичгийн тоог нэмэх.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг бий болгох.

## 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн шинэчлэл, чанарыг хэлэлцэх нэгж байгуулагдсан
- Багш, оюутан, хөтөлбөрийн албаны дэд систем ашигладаг (Гэрээтэй, шалгуур 2.3)
- Оюутнуудын санал хүсэлтийг авч, хөтөлбөрт тусгадаг
- Багшийн аттестатчилал явагддаг (2019.09.18 А/107 тушаалын нэгдүгээр хавсралт)

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын саналыг харгалзах.

### Зөвлөмж:

- Багш, оюутнуудад зориулсан дүрэм, журмыг системд нээлттэй байршуулах
- Ажил олгогчдоос төгсөгчдийн харилцаа, гоо зүй, хандлагад анхаарах хэрэгтэйг хэлж байв. Сургалтын төлөвлөгөөнөөс харахад Гоо зүйн хичээл нь сонгон судлах ангилалд багтаж байгаа бөгөөд оюутнууд гадаад хэл зэргийг судалж, сонгохгүй орхигддог. Иймд нэмэлт хөтөлбөр, эсвэл оюутны клубын үйл ажиллагаа зэргээр мэдээлэл өгөх гаргалгаа хийх.

#### 4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Урлаг, соёлын дотоод, гадаадын байгуулагатай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд хамтран ажилладаг

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн ажлын байрны хангалт маш сайн.

### **Анхаарах асуудал:**

- Дотоод, гадаадын ижил чиглэлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг сургалтын байгууллагатай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх

### **Зөвлөмж:**

- Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх
- Зочин профессор урих, оюутан солилцоог нэмэгдүүлэх гэх мэт

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Төсвөөс санхүүждэг.
- Сургалт, үйл ажиллагааны зардлаас эрдэм шинжилгээ, судалгааны төсвийг гаргадаг

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Дуурийн тавил хичээлийн хүрээнд бүхэл бүтэн томоохон хэмжээний дууриудыг бүтээж тоглон, төгсөлтийн шалгалт өгдөг. Гагцхүү энэ ажлын санхүүжилт хаана ч тусгагдаагүй байгааг цаашид анхаарч ажиллах

### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээний ажлыг тайлан тоглолт, мэргэжлийн урлагийн үйл ажиллагаагаар дүйцүүлдэг.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил зарцуулах төсөв бага

### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ, инноваци хөгжүүлэх бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх
- Өөрийн үйл ажиллагаагаар орлого олох механизм бүрдүүлэх (инноваци, бүтээл)
- Эрдмийн зэрэг, цолтой багшийг нэмэгдүүлэхэд төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, бүтээлийн чөлөө олгох зэргээр дэмжих.

### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багш нар олон улсын уралдаан, тэмцээнд шүүгчээр оролцдог. (шагнал, цом, бусад нотлох баримттай танилцав)
- Оюутнууд дотоод, гадаадын мэргэжлийн уралдаанд амжилттай оролцож байгаа. (Өөрийн үнэлгээний тайланд тусгасан)
- Нээлттэй хичээл тогтмол явуулдаг. (CD, материал)

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Багш хоорондын хамтын ажиллагаа маш сайн байгаа нь хөтөлбөр тогтвортой байдлаа хангах нөхцөл болж байна.
- Хөтөлбөрөөр суралцагсад болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нь хөтөлбөрийн төдийгүй сургуулийн маркетингийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

### Анхаарах асуудал:

- Олон талт хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж, хөтөлбөрийг сурталчлах, хөтөлбөрөөр суралцагчдыг хөгжүүлэх

### Зөвлөмж:

- Стратеги төлөвлөгөөний анхан шатны хэлэлцүүлэг явагдсан ч батлах үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Хөтөлбөрийн баг нь урт ба богино хугацааны төслийг дэвшүүлж, хэрэгжүүлдэг үнэлүүлдэг байх

### 4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- МУК-ын вэб сайтаар үйл ажиллагаагаа сурталчилдаг
- Урлаг, соёлын байгууллагатай хамтарсан тоглолт зохион байгуулах, багш оюутны тайлан тоглолт зэргээр олон нийтийг соён гэгээрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулдаг (өөрийн үнэлгээний тайланд тусгагдсан)

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Жил бүр бие даасан уран бүтээл хийдэг (Дуурь бусад)

### Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааны үр дүн, судалгаанд суурилсан урлаг, соёлын бүтээл нэмэгдүүлэх (ном, гарын авлага, ЭШӨ гэх мэт)

### Зөвлөмж:

- Цахим орчинд мэдээлэл түгээх олон сувгийг ашиглах
- Эрдэм шинжилгээний тогтсон сэтгүүл гаргах
- Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

### 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

## **Илрэл нотолгоо:**

- МУК-ын суралцагчдын элсэлт, сургалтын нөхцөл, хөтөлбөр, мэргэжлийн чиглэл, элсэлтийн бүртгэл, шалгалтын журам, БШУ-ын сайдын 2013оны А/79/ дүгээр БСШУЯ 2016оны А/87/ дугаарт тушаалын нэмэлт өөрчлөлтийг тусган баталсан.
- МУК-ын бакалаврын сургалтад 2019-2020 ны хичээлийн жилд оюутан элсүүлэх хөтөлбөр, ЭЕШ, бүртгэлийн босго оноо, ур чадварын шалгалтын агуулга баталсан.
- Дуулах урлаг, Ерөнхий шалгалт, Монгол хэл, гадаад хэл, Монголын түүх, Нийгмийн тухай мэдлэг, ЭЕШ 480 босго оноотой.
- Ур чадварыг, элсэгч тус бүрийг ганцаарчилсан хэлбэрээр дуулах ур зүй, сонсгол, ритм, хөгжим, шүлэг, этюд, бүжиг, анхаарал, урлагийн тухай ерөнхий ойлголт зэргийг дүгнэн шалгаруулна.
- Магистрт элсэгчдийн сургалтын хөтөлбөрт сонгодог ба Монголын хөгжмийн зохиолчдын том хэлбэрийн 2 бүтээл дуулуулж шалгалтын комиссын 5 гишүүнтэй 100 онооны журмаар дүгнэн шалгаруулдаг.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## **Онцлог зүйл/Туршлага:**

- 1950,1964,1974,1993 онуудад дуулаачийн тэнхимийг шинээр ба шинэчлэн байгуулж байсан уламжлалт хөтөлбөр, туршлага хуримтлагдсан. Сургалтын хөтөлбөр, агуулга, хэлбэр, практик дээр хангалттай туршигдан баталгаажсан бөгөөд орчин үеийн шаардлагаар шинэчлэгдэн сайжирсан.
- Зарим элсэгч, суралцагсад МУК-ын дунд шатлалын сургуулиас дамжин элсэх нь хөгжмийн боловсролын хувьд давуу тал болох бөгөөд бусад суралцагчиддаа эерэг нөлөөлөл болж сургалтын чанарт ахиц гарсан.

## **Анхаарах асуудал:**

- Тухайн хөтөлбөр, мэргэжилд өөрийн хүсэл сонирхол, ЭЕШ-ын өндөр онооноос гадна, элсэгчийн эрүүл мэнд, зөв төрх, биеийн ерөнхий хөгжлийг анхааран шалгаруулж авах.
- Элсэгчийн хувийн зан байдал, ёс зүйтэй холбоотой ярилцлага хийх.

## **Зөвлөмж:**

- Элсэгчдийн хүсэл сонирхлоос гадна ажил олгогч, МУК, хөдөө орон нутгийн захиргаатай хамтарсан зөвлөгөө хийж, хүний нөөцийн судалгаатай гурвалсан гэрээ байгуулан захиалгаар суралцуулах.
- Энэ нь суралцагчийн төлбөр, суралцах нөхцөл, чанарын шаардлагад оновчтой нөлөө үзүүлэх магадлалтай.

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

## **Илрэл нотолгоо:**

- МУК-ын сургалтын, оюутан элсүүлэх дадлаг хийх, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, оюутны шилжилт хөдөлгөөн, төгсөлтийн шалгалтын давхар

мэргэжлээр суралцах, олон улсын болон улсын тэмцээн уралдаанд бэлтгэн оролцуулах журмуудтай.

- Гадаад оюутан элсүүлэн суралцуулах гэрээтэй.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаатай.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Үйл ажиллагаануудыг дүрсжүүлэн МУК –ын урын санд хадгалдаг болсон.

Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаагаар МУК-ын төгсөгчид ҮУИТ-ын нийт уран бүтээлчдийн 66%, УДБЭТ-ын 82%, МУФ-ны 75.7%, МХЧ-ын 74.1%, Баян Монгол чуулга 56.2%, ЦДБЭЧ 63.3%, УБЧ 56.4%, Түмэн эх 39.1%, Сүлд чуулга 42.8% эзлэж, ур чадвар онолын мэдлэг 100% үнэлгээтэй гарчээ. Иймд МУК-ын төгсөгчид улсынхаа мэргэжлийн байгууллагуудад үндсэн хүний нөөц болон бэлтгэгдэн гарчээ.

#### **Анхаарах асуудал:**

- Төгөлдөр хууруудын хөглөгөөнд байнга чанарын үзлэг хийх
- Суралцагчдын хичээлийн болон давталтын цагийн хуваарийг мөрдүүлэн хяналт тавих.

#### **Зөвлөмж:**

- Мэдээлэл зүйн хичээлийн хөтөлбөрт нот бичих программуудыг ашиглан багш оюутан хамтран номын сангийн насжилт өндөртэй нотуудыг цахимжуулах. Ингэснээр суралцагчдын нот унших чадвар, онолын мэдлэг хөгжинө.

#### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Оюутны зөвлөлийн журамтай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл ЦЕГ-тай хамтран цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох зорилготой “ Unfriend” хөдөлгөөний хүрээнд сургалт хийсэн.
- Дэлхийн зөн олон улсын байгууллагын “Хөх тэнгэрийн хүүхдүүд” найрал дууны хамтлагтай хамтран 2014 оноос хойш хүүхэд ивээн тэтгэх, эрүүл мэнд, хүүхэд хамгаалах, гэр бүлийн сайн сайхан, гамшгийн эрсдэлийг даван туулах зэрэг хөтөлбөрт хамрагдан Н. Өнөдөлгэр, Т. Амарбаясгалан нар тэтгэлэг авсан.
- “Эх дэлхийгээ цэвэрлэх” өдөр 2018.09.15, ” Эрүүл оюутан хөгжлийн түүчээ” 2019 оны 10 сар, 12 сар, ДОХ-ийн эсрэг өдөрлөг, Зөв хооллолт, Оюутны шинэ жил, Хууль эрх зүйн бага наадам, Цус сэлбэлт судалгааны үндэсний төвтэй хамтран “ Амьдран бэлэглэе”, Дээлтэй Монгол аян зэрэг олон нийтийн сайн дурын үйл ажиллагаанд оролцдог. “Судлаач Оюунтан” клуб 2019.10.15 нд байгуулагдсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**



- Дотоод гадаадын А.В ангиллын уралдаанд байнга идэвхтэй оролцож Гранпри, I,II,III, тусгай байруудыг тогтмол эзэлдэг. 2018 онд АНУ-д “Crescendo” ОУ-ын уралдаанд Г. Ганбат, I-байр, БНХАУ-д 2017 онд Ц. Тэгшсүрэн III-байр эзэлсэн.
- Өндөр амжилт үзүүлсэн оюутнаа тухайн улирлын мэргэжлийн шалгалтаас чөлөөлдөг.
- Аливаа уралдаанд оролцох нь багш, оюутан, төгөлдөр хуурч нараас сургалтын тусгай хөтөлбөр бэлтгэж оролцохоос гадна, туршлага судлах, өөрийн түвшинг харьцуулах, тайзан дээрхи бие даасан байдал зэрэг олон талын ач холбогдолтой.

#### **Анхаарах асуудал:**

- Аливаа үйл ажиллагаанд оролцох санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх.

#### **Зөвлөмж:**

- ОУ-ын уралдаан тэмцээний мэдээллүүдийг судлан ганцаарчилснаас гадна найрал дуулаачдын, цөөхүүл, багаар шалгаруулах уралдаанд оролцох.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын журамтай. 2014 оноос хойш жилийн чөлөө авалт 14 оюутан байна. Тухайн чөлөө олголтыг сургуулийн захиргаа, эцэг эх, тэнхимийн багш нарын хамтарсан хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон талт үйл ажиллагаа, тоглолт, концертод байнга оролцдог байдал нь суралцагчийн уран бүтээлч болох тэмүүллийг дээшлүүлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчийн чөлөө авалтын үндсэн шалтгаан нь эрүүл мэнд, төлбөрийн чадвартай хамааралтай тул эерэгээр шийдвэрлэх аргуудад анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Шилдэг оюутнуудыг гадаадын хөгжмийн дээд сургуульд тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан суралцуулах боломжийг судлах

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- БСШУЯ-ны 2016 оны “Дээд боловсролын диплом олгох журам”
- 2015 оны ХБК-ын дээд боловсролын бакалавр-ын зэргийн диплом олгох тухай захирлын тушаал А/139/Дуулаач D 212701-р батлагдана
- 2018 оноос Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журам батлан мөрдөж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**



### **Онцлог зүйл/Туршлага:**

- Улсын шалгалтын комисст ажил олгогчдоос оролцуулан төгсөгчдийг ажлын байраар шууд хангадаг.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрөөр суралцагсдыг орон нутгийн гэрээгээр авч суралцуулах
- Төгсөгчдийн талаарх мэдээллийг орон нутагт явуулах, сурталчлах.
- Төгсөлтийн баримт бичгийн бичвэрт анхаарч ажиллах

### **Зөвлөмж:**

- Улсын шалгалт, диплом хамгаалатад салбарын эрдэмтдийг оролцуулж, зөвлөн туслах үйлчилгээг тогтмол авдаг болох
- Төгсөгчдийг цаашид эрдэм судалгааны ажилд оролцох, судалгаа шинжилгээ хийх сэдэлтэй болгох ажлыг төлөвлөн хийх.

## **5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2019-2024. Зургаан зүйл заалттай баталсан.
- Одоогоор Дуулаачийн тэнхим доктор 3, магистр 3, магистрант 4, 13н мэргэжлийн багштай ажиллаж байна. Б. Сүхээ ОХУ, Ч. Чинзориг, Болгар улсад, Ш. Чимэдцэеэ ХУИС тус тус докторын зэргээ хамгаалсан. МУАЖ 3, МУГЖ 6
- МУК-ын Удирдах зөвлөлийн 2019 оны тогтоолоор МУК-ын дүрэмд өөрчлөлт оруулан, сургуулийн бүтэц, удирдлагын тогтолцоо, эрдмийн зөвлөл, тэнхим, багш ажилтан, эдийн засаг санхүүжилтийг батлан (нийт 9 заалттай) сургалтын үйл ажиллагааг явуулж байна.
- МУК-ын хөдөлмөрийн дотоод журам захиралын тушаалаар батлагдан ажилтанг сонгон шалгаруулж авах, ажиллуулах гэрээг зохих зүйл заалтаар зохицуулна.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар нь олон жилийн уран бүтээлийн арвин сантай. Мэргэжлийн онол дадлага, ёс зүй, өндөр боловсролтой, сурган заах арга зүйн туршлагатай
- Ганцаарчилсан хэлбэрээр сургалтаа явуулдаг тул суралцагчид нөлөөлөх нөлөөлөл хувийн соёлоор үлгэрлэн заах арга барил сайтай.

- Суралцагч бүрийн онцлогт тааруулж сургадаг тул үндсэн хөтөлбөрийн шаардлага, ахин дэвших чанарыг тооцоолон үе шаттай сургалт явуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт зааж байгаа багш нарын эрдмийн зэрэг цолыг ахиулах.

#### **Зөвлөмж:**

- Багш нарын уран бүтээлийн тайлан тоглолтыг суралцагч нартай нь хамтарсан хэлбэрээр тогтмол явуулах.

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУК-ын захирлын 2019.03.13-ны А/29/ тушаалаар багшийн хөгжлийн төвийг байгуулж хариуцсан мэргэжилтний ажлын төлөвлөгөөг баталсан.
- -Бодлого, Эрх зүй, Заах арга зүй, Судалгаа, шинжилгээ, хувь хүний хөгжил, бусад гэсэн хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.
- “Эрдэмтний Индэр” лекц сард хоёр удаа ШУА-ын академич нараар лекц хийлгэсэн. Академич С. Нарангэрэл, Ш. Дэмбэрэл, Т. Ган-Эрдэнэ, Ш. Болд, С. Дэмбэрэл, Б. Авид, Б. Жадамба.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Дуулаачийн тэнхимдээ мэргэжлийг дээшлүүлэн, найрал дууны удирдаачаар ажиллах чадвар олгох сургалт явуулсан. Итали улсад Б.Жавзандулам, Болгар улсад Ч.Чинзориг, З.Оюунбилэг, ОХУ-д У.Цэрэнчунт, Г.Саранчимэг нар нь мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.
- Дуулаачийн тэнхимийн багш нар бүгд мэргэжлийн уран бүтээлч, сурган хүмүүжүүлэгч нар юм.

#### **Анхаарах асуудал:**

- Гадаад орнуудын мэргэжил нэгт багш нартай хамтарсан нээлттэй хичээл, туршлага судлах сургалтуудыг тогтмолжуулах.

#### **Зөвлөмж:**

- Мэдээлэл зүй, цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ тутамд гарч буй програм хангамжийг нэвтрүүлж ажиллах.
- Багш нарын залгамж холбоог үе шаттай бэлтгэж, багшаа хөгжүүлэх

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУК-н эрдмийн зөвлөл байгуулж дүрэм батлах тухай, захирлын 2018 оны А-90 тушаал гаргасан.

- МУК-н хүндэт цол олгох журам, Дуулаачийн тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний илтгэл, гарын авлага, удирдамж, багш оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зохион байгуулах удирдамж тушаалыг гаргасан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эрдмийн ажлын судалгаа практик үйл ажиллагааг хослуулсан.
- Дуулаачийн тэнхимийн багш нарын илтгэлийн эмхтгэлийг гаргасан.

#### **Анхаарах асуудал:**

- Дуулаачийн тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээний ажлуудыг мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэргэжилтэн уран бүтээлчидтэй хамтран дүгнэх.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын эрдэм шинжилгээний санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах

#### **Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээний судалгааны ажлыг гадаад улсад сурталчилж, өөрийн орны онцлогийг таниулах.
- Эрдэм шинжилгээний бичигт судалгаа шинжилгээний үр дүнгээ тогтмол хэвлүүлдэг байх
- Эрдэм шинжилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэхэд анхаарч төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, ном сурах бичиг гарын авлагыг санхүүжүүлэн хэвлэдэг байх

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУК-н захирлын 2019-оны А-107тоот тушаалаар Аттестатчиллын журам, үйл ажиллагааны график, явцын тайлан үр дүн гаргаж аттестатчилалтай холбоотой судалгаа хийсэн.
- МУК ХУ, дуулаачийн сургуулийн 2015-2019 оны хичээлийн жилийн өөрийн үнэлгээний тайлан.
- Төгсөгчдийн судалгааг сүүлийн 5-н жилээр хийж ажлын үр дүн, амжилтыг дүгнэсэн.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн заах арга зүй, сургалт, дадлага, судалгааны уялдааг сайжруулахад анхааран ажиллаж байна

#### **Анхаарах асуудал:**

- Багш нарын эрдэм шинжилгээ судалгаа, оюутнуудаа ОУ-н тэмцээн уралдаанд бэлтгэн оролцуулах санхүүгийн дэмжлэг дутмаг байна.

#### **Зөвлөмж:**

- Нэр хүнд бүхий ОУ-н уралдаан тэмцээнд оюутныг мэргэжлийн, төгөлдөр хуурч багшийн хамт оролцуулах нь амжилт үзүүлэхэд эерэг нөлөөтэй.
- ОУ-н чанартай уралдаан тэмцээнд шилдэг багш, төгөлдөр хуурчийг шалгаруулж дүгнэдэг журмын дагуу үнэлүүлэх.

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

##### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дотоод хяналт, шалгалтын орон тооны бус зөвлөл байгуулсан. Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний журмын төсөл байна.
- Чанарын алба, нэгж байхгүй байна. Чанарын баталгаажуулалтын гарын авлага байхгүй байна. Сэтгэл ханамжийн судалгаанууд тогтмол хийгддэггүй байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУК-д удирдлага, мэдээллийн систем нэвтэрч, хөтөлбөрийг сайжруулах талаар хяналт тавин ажиллаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Дуулах урлаг хөтөлбөрийн орц, гарцыг тодорхой болгох

#### **Зөвлөмж:**

- Дуулах урлаг хөтөлбөрт элсэн орж байгаа хүүхэд сурах явцдаа хэрхэн хөгжиж байгаа болон төгсөхдөө ямар түвшинд хүрч, мэргэжил эзэмшиж буйг илүү тодорхой болгосон судалгааг хийх
- Бие даасан чанарын алба байгуулж ажиллах, чанарын алба нь чанарыг дээшлүүлэх чиглэлд хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж ажиллах, дотоод чанарын баталгаажуулалтын гарын авлагатай болох. Чанарын болон тоон судалгааны арга, аргачлал, статистик боловсруулалтыг чанаржуулах

##### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

**Илрэл нотолгоо:** Төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгөх судалгааг сүүлийн таван жилээр гаргаж үзүүлсэн байна. Нийт 12 төгсөгчдийн гавьяа шагнал, гадаад, дотоодын уралдаан тэмцээний шагнал, тэтгэлэг зэргийг харуулсан. Ажил олгогчид, төгсөгчид, оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнтэй танилцсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн ажил эрхлэлт өндөр хувьтай байгаа нь эрэлт хэрэгцээг хангаж байгаагийн илрэл юм.

#### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ, багш нарын судалгааг дэмжих тал дээр анхаарах

#### **Зөвлөмж:**

- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, үр дүнг нь цалин урамшуулалд тооцдог болох.

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:** Магадлан итгэмжлэлд зохих журмын дагуу эрх зүйн баримт бичгүүдийг гарган бэлдсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Анх удаагаа магадлан итгэмжлэл хийлгэж байгаа.
- Тухайн сургуулийн багш нар, төгсөгч, оюутны мэргэжлийн дуулах урлагийн салбарт гаргасан амжилт, гавьяа шагнал нь энэ хөтөлбөр үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзэх бүрэн үндэслэл болно.
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаанаас үзэхэд мэргэжлээрээ ажиллаж байгаа болон үргэлжлүүлэн суралцаж байгаа хувь 92,6 байна. Энэ бол онцлох том давуу тал юм.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын хөтөлбөр гадаад хэлний хичээлүүд байгаа боловч, дэлхийн хэмжээнд өрсөлдөх боловсон хүчин бэлдэхэд англи хэлний мэдлэг чухал болохыг анхаарах
- Гадаад харилцааг улам хөгжүүлж, бусад олон их сургуулиудтай гэрээ, хамтын ажиллагаа, хамтарсан хөтөлбөрүүдийг хөгжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Оюутны дадлага хийж байгаа мэргэжлийн урлагийн байгууллагуудтай харилцан ашигтай ажиллах, цалинтай дадлага хийлгэх нөхцөл бололцоог бий болгох

**7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

**ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Консерваторийн Хөгжмийн ухаан дуулаачийн сургуулийн Дуулаачийн тэнхим, хамт олны боловсруулсан “Дуулах урлаг” бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан болон тайлантай холбогдох нотлох баримтуудтай танилцсан. Мөн Монгол Улсын Консерваторийн хичээлийн байр, орчинтой биечлэн танилцсан болон багш, ажил олгогч, төгсөгч, оюутны төлөөлөлтэй хийсэн уулзалтууд зэргийг үндэслэн тус сургуулийн “Дуулах урлаг” бакалаврын хөтөлбөрийг шалгуурыг бүрэн хангасан гэж дүгнэсэн болно.

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2 Сургалтын үйл ажиллагаа	3			
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3			
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1		4.3. Санхүүжилт
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6 Багшлах үйл ажиллагаа	4			
7 Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1		7.1.Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт,
<b>Дүгнэлт</b>	<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Консерваторийн Хөгжмийн ухаан дуулаачийн сургуулийн “Дуулах урлаг” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуурт нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... /А.Энхбат/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Л.Мөнхтуяа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Н.Дашбямба/

## ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрт харилцааны соёл, ёс зүйн хичээлүүдийн агуулгыг нэмэх.
2. Багш, оюутнуудад Удирдлага мэдээллийн систем ашиглах арга зүйн зөвлөмж, удирдамж боловсруулж, системд байршуулах.
3. Оюутны цайны газарт онцгой анхаарал хандуулах. Оюутнуудтай хийсэн уулзалтаар их шүүмжлэлтэй хандаж байсан.
4. Эрдэм шинжилгээний тогтсон сэтгүүлтэй болж, багш нарын эрдэм шинжилгээний ажил хийх сонирхлыг хөгжүүлэх, тэдний эрдэм шинжилгээний ажлыг дэмжиж, үр дүнд нь цалин урамшуулалд тооцдог болох.
5. Гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
6. Мэдээлэл зүй, цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ тутамд гарч буй програм хангамжийг нэвтрүүлж ажиллах.
7. Оюутны дадлага хийж байгаа мэргэжлийн урлагийн байгууллагуудтай харилцан ашигтай ажиллах, цалинтай дадлага хийлгэх нөхцөл бололцоог бий болгох
8. Чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлж ажиллах, хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлага боловсруулах. Чанарын болон тоон судалгааны арга, аргачлал, статистик боловсруулалтыг чанаржуулах.

## IV. Ярилцлагад оролцогчдын нэрс


**МОНГОЛ УЛСЫН  
КОНСЕРВАТОРИ**
**Төгсөгчдийн төлөөлөл**

№	Төгсөгчдийн нэрс	Ажлын газар, албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	Баяраа Одмандах	“Сүлд” чуулгын дуучин	95917292	Odmandah6@gmail.com
2	Түмэндэмбэрэл Баатархүү	ҮУИТ-дуучин	96629293	Baatarhuu_2210@yahoo.com
3	Жамбалжав Хишигбат	ХЦДБЭЧ-дуучин	99904637	khishigbatjambaljav@gmail.com
4	Дүйнхэржав Олонбаяр	ОХУ-ын Новосибирскийн Консерватори	88336010	Olonbayar.duinkherjav@yahoo.com
5	Лхагвадорж Бүүвэйбаатар	УДБЭТ-ын гоцлол дуучин	86009050	Buuwei6349@gmail.com
6	Батбаяр Чинбаатар	ХЦДБЭЧ-н дуучин	94755339	Chinba249@gmail.com
7	Батбаяр Мөнхбаяр	ДБЭТ-ын дуучин	88104406	Bayarka_@yahoo.com
8	Эрдэнэбат Отгонбат	УДБЭТ-н гоцлол дуучин	99213645	Otgonbate1@gmail.com
9	Гал-Эрдэнэ Дашчанрав	УДБЭТ-н гоцлол дуучин	88057699	Dshchnrv555@gmail.com

**Оюутны төлөөлөл**

№	Оюутны нэрс	Анги, мэргэжил	Утас	Мэйл хаяг
1	А.Мөнгөнбагана	4-р курс дуурийн дуулаач	99390095	Bagnamungun929@gmail.com
2	О.Учрал	4-р курс дуурийн дуулаач	99842403	uchraloyuntsetseg@gmail.com
3	С.Цэнгүүн	4-р курс уртын дуулаач	96654919	Aylquu_s@yahoo.com
4	О.Дулмаа	2-р курс дуурийн дуулаач	99527999	Odulmaa0214@gmail.com
5	Б.Халиун	2-р курс дуурийн дуулаач	95188498	hhaliun535@gmail.com
6	А.Лувсандорж	4-р курс уртын дуулаач	88243655	
7	Г.Чинбаатар	4-р курс дуурийн дуулаач	96979998	
8	Н.Ариунзаяа	4-р курс дуурийн дуулаач	80039029	



### Ажил олгогчдын төлөөлөл

№	Төгсөгчдийн нэрс	Ажлын газар, албан тушаал	Утас	Мэйл хаяг
1	Ц.Төвшинтөгс	УДБЭТ-ын дарга МУГЖ	88103355	Tuvshintugs3355@gmail.com
2	Н.Ариунзаяа	ЦДБЭЧ-ийн Хормейстр	96001681	Ayalguu_ariuna@yahoo.com
3	Б.Баттулга	Улсын филормони дарга	99117586	Battulga.su@gmail.com
4	Б.Ганхуяг	ХЦДБЭЧ-ийн дарга	88092750	<a href="mailto:Ydmaa_9@yahoo.com">Ydmaa_9@yahoo.com</a>
5	Н.Үенч	ХЦДБЭЧ-ийн хормейстр	88078868	Uench@gmail.com
6	Г.Содномдаржаа	Цагдаагийн “Сүлд” чуулга Дуу ангийн багш	96446601	Sodnomdarjaa.dashnyam@gmail.com
7	П.Урнаа	Нийслэлийн Улаанбаатар чуулга УС-ийн удирдаач	89107887	Urnaa107887@gmail.com
8	Н.Наранхүү	Дорнод аймаг ХДТ-ийн дарга	99088410	Do.Khdteatr@gmail.com
9	Н.Энхбаяр	Хан Хэнтий чуулгын хормейстр		Enkhbayar.byambaa@gmail.ru
10	Д.Отгонбаатар	Төв аймаг “Монгол туургатан” театрын хормейстр	99236147	otgonbaatar dagvanamdal@gmail.com

### Багш нарын төлөөлөл

№	Багш нарын нэрс	Албан тушаал, тэнхим	Утас	Мэйл хаяг
1	Х.Алтангэрэл	ХУДС-ийн захирал	99021225	Altay7727@yahoo.com
2	Д.Түвшинжаргал	МУАЖ мэргэжлийн багш	99161819	Damdin.tuwshinjargal@gmail.com
3	Б.Жавзандулам	МУАЖ мэргэжлийн багш	99789989	Baasanhuu55@yahoo.com
4	А.Бүтэд	МУГЖ мэргэжлийн багш	99151122	Altangerelbuted1@gmail.com
5	Ч.Туул	МУГЖ мэргэжлийн багш	99067540	Tuulchadraabal27@gmail.com
6	Д.Долгормаа	МУГЖ мэргэжлийн багш	99041135	Neenee_b2000@yahoo.com
7	Ц.Ерөө	МУГБ мэргэжлийн багш	99491211	
8	Л.Идэрбат	МУГЖ концертмейстр	99796323	
9	Б.Батмэнд	СТА мэргэжлийн багш	99010608	Баасанхүү Батмэнд
10	Ө.Цэрэнчунт	Мэргэжлийн багш	99096295	tserenchunt@mail.ru
11	Х.Одцэцэг	Мэргэжлийн багш	90000070	Oдноos54@gmail.com
12	С.Сүрэнхүү	СТА концертмейстр	95257253	Сүх Сүрэнхүү
13	О.Нармандах	СТА концертмейстр	99328598	
14	Д.Отгонжаргал	СТА концертмейстр	99163320	Otgoodash2@gmail.com



МОНГОЛ УЛСЫН  
КОНСЕРВАТОРИ

МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИД АЖИЛЛАХ ШИНЖЭЭЧДИЙН АЖЛЫН  
ЦАГИЙН ХУВААРЬ

2020 оны 5 дугаар сарын 25-26

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 сарын 15-ны өдрийн Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тушаал шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Консерваторийн Хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шинжээчдийг ажиллуулна.

1. 5 сарын 25-26-ны өдрүүдэд МУК-н хичээлийн 1 дүгээр байрны №323 тоот танхимд хорио цээрийн дэглэмийг баримтлан суудлыг 2 метрээс доошгүй зайтай байхаар байрлуулж, шинжээчид ажиллахаар бэлтгэнэ.
2. Хорио цээрийн дэглэмийг баримтлан уулзалт ярилцлагуудыг цахимаар зохион байгуулж шаардлагатай тохиолдолд уулзалтын тусдаа өрөө гарган 1-2 хүнтэй уулзалт хийнэ.
3. Шинжээчдийн ажлын хуваарь

Хугацаа	Үйл ажиллагаа	Хаана
<b>2020-05-25 Даваа гараг</b>		
10.00-11.00	Шинжээчийн багийг угтах	Хичээлийн 1-р байр, Номын сан 4-р давхар
	Шинжээчийн багийг танилцуулах	
	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн танилцуулга хийх	
11.00-11.30	Сургуулийн орчинтой танилцах	Хичээлийн 1, 2-р байр, оюутны дотуур байр
11.30-12.30	Хөтөлбөрийн багш нарын төлөөлөгчтэй шинжээчийн баг уулзах	Хичээлийн 1-р байр, Номын сан, 4-р давхар
12.30-13.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө
13.00-14.00	Цайны цаг	Хичээлийн 1-р байр 302 тоот өрөө
14.00-15.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө

15.00-15.30	Ажил олгогчийн төлөөлөлтэй цахим уулзалт	
15.30-16.00	Төгсөгчдийн төлөөлөлтэй хийх цахим уулзалт	
16.00-17.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө
<b>2020-05-26 Мягмар гараг</b>		
10.00-11.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө
11.00-11.30	Суралцагсдын төлөөлөлтэй хийх цахим уулзалт	
11.30-13.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	
13.00-14.00	Цайны цаг	Хичээлийн 1-р байр 302 тоот өрөө
14.00-15.00	Шалгуур үзүүлэлтийн нотлох баримтуудтай ажиллах	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө
15.00-15.30	Шинжээчийн багийн хэлэлцүүлэг, үнэлгээ	Хичээлийн 1-р байр 323 тоот өрөө Хичээлийн 1-р байр, Номын сан 4-р давхар

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
**/албан бичгийг оруулах/**



**МОНГОЛ УЛСЫН  
КОНСЕРВАТОРИ**

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

2020.06.09

Шинжээчийн дүгнэлтийн тухай

Монгол Улсын Консерваторийн Хөгжмийн ухаан, Дуулаачийн сургуулийн “Дуулах урлаг” D 021503 бакалаврын хөтөлбөрийг анх удаа магадлан итгэмжлүүлэхээр зохих журмын дагуу БМИҮЗ-д хандаж “Өөрийн үнэлгээний тайлан”-г хүргүүлсэн болно. Улмаар БМИҮЗ-ийн ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон шинжээч нар тус сургуульд ажилласан. БМИҮЗ-өөс томилогдон ажилласан “Шинжээчийн тайлан”-г хүлээн авч танилцлаа.

МУК-ийн “Дуулах урлаг” D 021503 бакалаврын хөтөлбөрийн баг БМИҮЗ-ийн шинжээчийн тайлан, дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, холбогдох зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа анхаарч хэрэгжүүлэх болно гэдгийг үүгээр уламжилж байгааг хүлээн авна уу.

Хамтын ажиллагаанд талархаж байна.



Монгол Улсын Консерваторийн дэд захирал Ш.Ариунаа Доктор (Sc.D), профессор

## ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

**Зөвлөмж /Recommendations/**